

2026 оны 05 дугаар
сарын 29 -ны өдөр

№: 26/08

Улаанбаатар
хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн
мэдээлэлд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, 80 дугаар зүйлийн 80.2 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн эчнээ санал хураалтын үр дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Улсын их дэлгүүр” ХК-ийн өмчлөлийн дор дурдсан үл хөдлөх эд хөрөнгүүд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газарт орон сууцны зориулалтаар бүртгэлтэй байгааг өөрчлүүлж, үйлчилгээний зориулалтаар бүртгүүлсүгэй. Үүнд:
 - 1.1. Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 3 дугаар хороо, Энхтайваны өргөн чөлөө хаягт байршилтай, улсын бүртгэлийн 2202006240 дугаартай, 12,479 м.кв талбай бүхий Улсын их дэлгүүрийн барилгын А хэсэг;
 - 1.2. Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 3 дугаар хороо, Энхтайваны өргөн чөлөө хаягт байршилтай, улсын бүртгэлийн 2202006253 дугаартай, 9787.8 м.кв талбай бүхий Улсын их дэлгүүрийн барилгын Б хэсэг;
 - 1.3. Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 3 дугаар хороо, Энхтайваны өргөн чөлөө хаягт байршилтай, улсын бүртгэлийн 2202006254 дугаартай, 90 м.кв талбай бүхий цахилгаан дэд өртөөний барилга;
2. Энэхүү тогтоолын нэгдүгээр хэсэгт заасан үл хөдлөх эд хөрөнгүүдийн зориулалтыг өөрчлүүлэхтэй холбогдуулан үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн гэрчилгээг хөрөнгө тус бүрээр шинэчлэн гаргуулсугай.
3. Компанийн өмчлөлийн үл хөдлөх эд хөрөнгүүдийн зориулалтыг өөрчлүүлэх өргөдөл, хүсэлт гаргах, холбогдох баримт материал бүрдүүлэх, бүртгэл хийлгэх, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн гэрчилгээг хүлээн авах эрхийг ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Мөнхбаярын Өлзийбат (РД: АИ84122114)-д итгэмжлэн олгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Я.НАВААН